МОНГОЛ УЛС
**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2017 оны 06 сарын 19 өдөр Дугаар 1/218 Мандалговь

Дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1, Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоолын 2, 3-р заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх “Дундговь аймгийн дэд хөтөлбөр”-ийг хавсралт 1-ээр, 2017-2021 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралт 2-оор тус тус баталсугай.

Хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулалт, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газар /Ц.Энхсайхан/, харъяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хэрэгжилтийг хангаж, зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

Гурав. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх “Дундговь аймгийн дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилтэнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөв болон орон нутгийн хөгжлийн сан, олон улсын төсөл хөтөлбөрийн төлөвлөгөөнд тусгах замаар санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /А.Ганбат/, Эрүүл мэндийн газар /Ц.Энхсайхан/, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

Дөрөв. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогыг хэлтэс /Ц.Эрдэнэсүрэн/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА О.БАТ-ЭРДЭНЭ

0200636